

**БНМАУ-ЫН ХАРЬАТ БОЛОГСДЫН СУДАЛГАА
(1961-1990 ОН)**

О.ОДСҮРЭН
Н.АЛТАНТӨГС

Хураангуй: 1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо зарласан цагаас эхлэн Монгол угсаатнаа нэгтгэх бодлогыг XX зууны дунд үе буюу 1945 оны Чөлөөлөх дайныг дуустал тууштай барьж ирсэн билээ. Гэвч тухайн үеийн геополитикийн нөхцөл байдал, их гүрнүүдийн ашиг сонирхлоос шалтгаалж энэхүү бодлого тэр бүр амжилт олсонгүй. 1949 онд БНХАУ байгуулагдсанаас хойш, ялангуяа 1960 оноос БНМАУ гадаад, дотоод бодлогодоо бүх талаар социалист интернационалч бодлого явуулж эхлэн үндэсний үзлийг илтээр буруушаан, хориглож, үндэстнээ нэгтгэх бодлого ил байдлаар алга болжээ. Гэвч бодит байдал дээр БНМАУ гадаадын иргэдийг харьяат болгон авахдаа монгол угсаатныг илүүтэй харьяат болгон авч байсан бөгөөд монгол угсаатнаа нүүлгэн ирүүлэх угсаатан-хүн ам зүйн бодлого социалист интернационалч үзлийн цаана ч далд байдлаар үргэлжилж байв.

Түлхүүр үг: БНМАУ-ын харьяат бологсод, БНХАУ, ЗХУ, Үндэсний үзэл, Өвөр Монгол

Үндэсний үзэл ба социалист интернационализм

1953 онд Сталин нас барсны дараа социалист блокийн цаашдын ирээдүйг хэн авч явах асуудал ЗХУ-ын эрх баригчдын өмнө тулгарав. Удалгүй ЗХУ-ын төрийн эрхийг Намын Хорооны дарга байсан Н.С.Хрущев залгамжлан авчээ. 1956 оны 4-р сард ЗХУКН-ын XX их хурал хуралдаж, уг хурлын төгсгөлд Н.С.Хрущев өөрийн алдарт нууц илтгэлээ тавьж, үүндээ нэг хүнийг тахин шүтэх явдал болон түүний хор уршгийн талаар, социализмын урхагшсан байдлыг арилгах талаар анх удаа хөнджээ. Энэхүү илтгэлийн үр дүн удалгүй социалист блокийн бүх орнуудад нөлөөгөө үзүүлэв. Зарим орнуудад социализмыг эсэргүүцсэн бослого хөдөлгөөнүүд гарч, цаашлаад үндэсний үзэл илт сэргэж эхэлжээ. Гэвч энэхүү үзэл бодлын дулаарлын араас үндэсний үзэл, олон ургалч үзэл гаргасан хүмүүсийг буруушааж, хавчиж эхлэн, цаашлаад социалист блок өмнөхөөсөө илүү чанга, хатуу дарангуйлал руу шилжив.

1960 онд БНМАУ өөрийн шинэ Үндсэн хуулиа баталсан бөгөөд уг хуулийн 76-р зүйлд “БНМАУ-ын иргэд эрэгтэй, эмэгтэй, яс, үндэс, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй”¹, 83-р зүйлд “БНМАУ-ын иргэд яс үндэс ялгаваргүйгээр улс орныхоо төр, аж ахуй, соёл, нийгэм улс төрийн бүх ажилд тэгш эрхтэй оролцоно. Арьс, үндэс ялгаварлаж, дээрэнгүй, үндсэрхэх үзэл гаргаж, иргэдийн эрхийг шууд буюу шууд бусаар хязгаарлахыг хуулиар хориглоно”² гэж зааснаар БНМАУ социалист интернационалч үзлийг үндэсний асуудлаас дээгүүр тавьж, үндэсний үзлийг хуулиар хоригложээ. БНМАУ-ын төр засагт үндэсний үзэл ямар нэг байдлаар үлдэж хоцорсон уу? Олон хуваагдаж салж бутарсан монгол овогтныг ямар нэг байдлаар эргүүлэн уулзуулах санаа бодол Монголын социалистуудад байв уу? Бид энэ асуултад ямар нэг байдлаар хариу олохын тулд БНМАУ-ын харьяат болсон гадаадын иргэдийн статистик дүнг ажиглах хэрэгтэй.

Судлаач Ц.Нэргүй, Н.Золзаяа, Х.Мэндсайхан нар Монголын харьяат, цагаачлалын түүхээр нэгэн сэдэвт бүтээл³ гаргасан нь гадаадын харьяат иргэдийн талаарх сэдвийн хүрээнд гарсан хамгийн анхны том бүтээл болжээ. Зохиогчид уг бүтээлдээ нэн эртнээс буюу Хүннү гүрний үеэс 1922 он хүртэлх Монголын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан улсуудын гадаад бодлого, харьяат, цагаачлалын талаар гаргаж байсан дүрэм, зааврыг архивын баримттай дэлгэн үзүүлсэн байна.

2008 онд судлаач Х.Мэндсайхан уг судалгааны он цагийн хүрээг ахиулан 1921-1930 оны хооронд судлан өгүүлэл бичсэн байна.⁴ 2012 онд Хатанбатын Мэндсайхан нь уг судалгаагаа мөн л ахиулан 1921-1940 оны Монгол улсын иргэн харьяатын асуудлыг эрх зүйн талаас нь судлан нэгэн сэдэвт ном⁵ гаргасан байна. Зохиогч уг бүтээлдээ Богд хааны Засгийн газрын үеэс гадаадын иргэдийг бүртгэх, хянах талаар хэрэгжүүлж байсан бодлогын уламжлалыг дурдаад Монголын төр, засгаас тус улсад оршин сууж байсан гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг 1921-1940 онд хэрхэн шийдвэрлэсэн, үүнээс үүдсэн сургамж, туршлагыг анх удаа иж бүрнээр харуулахыг оролдсон байна.

Богд хаант Монгол улс болон БНМАУ-д бөөнөөр дагаар орсон явдлуудыг судалсан судалгааны бүтээлүүд мэр сэр байна. 2007 онд судлаач Г.Мягмарсамбуу Баргын нүүдэл, суудлын талаар нэгэн сэдэвт бүтээл⁶ гаргасан. Мөн Чөлөөлөх дайны дараачаас БНМАУ-руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, Өвөр монголчуудын

¹ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, Улс төр, Эрх зүйн дэлгэрэнгүй тайлбар*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1988, 204

² Мөн тэнд, 220

³ Нэргүй, Ц., Золзаяа, Н., Мэндсайхан, Х., *Монголын харьяат, цагаачлалын түүх (нэн эртнээс-1922 он хүртэл)*, Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК 2006

⁴ Мэндсайхан, Х. “Монгол улсын төрөөс гадаадын иргэн, харьяатын талаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ (1921-1930)”, *Acta Historica IX*, 2008, 233-242

⁵ Мэндсайхан, Х. *Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал: 1921-1940*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2012

⁶ Мягмарсамбуу, Г. *Баргын эрх чөлөөний тэмцэл: Нүүдэл, суудал*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2007

талаар судлаач Н.Хишигт⁷, Б. Хөхбаатар⁸ нарын судалгааны бүтээлийг дурдаж болно.

Сүүлийн үед гадаадын харьяатуудын асуудлуудыг хүн ам зүйн талаас нь судалсан өгүүллэгүүд хэвлэгдэн гарч байна. Судлаач Н.Алтантөгс БНМАУ-д 1954 онд Хятад ажилчдыг ирүүлсэн явдлын цаана монголчууд ажиллах хүчний хомсдолоо шийдвэрлэх зорилтоос гадна БНХАУ-д буй монгол угсаатнуудыг нүүлгэн ирүүлэх уламжлалт хүн ам зүйн бодлогыг давхар агуулж байсан талаар санал дэвшүүлжээ⁹. 2021 онд судлаач Ш.Гэрэл¹⁰ БНМАУ-ын харьяат болох санал тавьсан Япон болон Хятад хоёр иргэний өргөдлийг шинжлэн дүгнэж, үүнийг эрх зүй болоод хүн ам зүйн бодлого талаас нь тайлбарлахыг оролджээ.

Ийнхүү БНМАУ-ын харьяат иргэн бологсдын судалгааны он цаг 1950-иад он хүрээд зогсож байгаа бөгөөд 1950-1990 оныг хүртэлх БНМАУ-ын гадаад харьяат, иргэн бологсдын судалгаа маш хомс, бараг хийгдээгүй байна. Энэхүү судалгаагаар 1961-1990 оны хооронд БНМАУ-ын эрх баригчид харь улсын харьяалалтай монголчуудад зориулсан хүн ам зүйн бодлого баримталж байсан эсэхийг гаргаж ирэхийг зорив. Уг судалгааг МУҮТА-т хадгалагдаж буй БНМАУ-ын харьяат бологсдын судалгаа, өргөдөл, тодорхойлолт, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигууд зэрэг албан ёсны баримтуудыг ашиглан эрх зүйн орчин, түүх, хүн ам зүйн бодлогыг судалсан болно.

Мөн тус судалгаа нь 1961-1990 оны хооронд зөвхөн хууль ёсны дагуу БНМАУ-ын харьяат болсон гадаадын иргэдийг хамарсан бөгөөд амьдрах эрх авагчид, түр хугацаанд ажиллагчид, цагаачлагчид, хууль бусаар оршин суугчид болон БНМАУ-ын харьяаллаас гарч байсан хүмүүсийг хамраагүй болно.

БНМАУ-ын гадаадын иргэдийг харьяат болгон авах эрх зүйн орчин

1911 оны 12-р сарын 29-нд Халхууд тусгаар тогтнолоо зарласны дараа бусад Монгол үндэстнүүд тус шинэ улсад нэгдэн орох хөдөлгөөн Хянганаас Алтай, Цагаан хэрмээс Байгал далайн хоорондох өргөн уудам нутагт өрнөв. Тухайн үед бөөнөөр орж ирэн харьяат болохыг хүссэн иргэд шууд Богд хаанд хүсэлтээ илтгэн, хүсэлтийг нь Богд хаан шийдвэрлэн дагаар ордог байсан бөгөөд тухайн үед дагаар орох харьяатуудын асуудлыг зохицуулах эрх зүйн орчин, засаг захиргааны шийдвэрлэх нэгж гэх мэт ойлголт байгаагүй байна. Харин энэ үеэс цаашид орж ирэх гадаадын харьяатуудыг болон дотооддоо байгаа гадаадын харьяатуудыг хэрхэн шийдвэрлэх байх тухай асуудал урган гарсан байна. Гэвч гадаад, дотоод нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалж, Бүгд Найрамдах

⁷ Хишигт, Н. “Тусгаар тогтнолын асуудал”, Эрдэмтдийн үг цуврал лекц 10, 2016

⁸ Хөхбаатар, Б. “БНМАУ-ын 1945 оны Чөлөөлөх дайны зорилт ба Өвөр Монгол”, XX зууны Монголын түүх, соёлын зарим асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019

⁹ Алтантөгс, Н. 1954 оны Монгол-Хятадын ажиллах хүчний хэлэлцээрийн хүрээнд Өвөр Монголоос ажилчин авах Монголын бодлого. *Journal of International Studies*. 46, 115 (Nov. 2023), 96–110. DOI: <https://doi.org/10.5564/jis.v46i115.3081>

¹⁰ Гэрэл, Ш. “БНМАУ-ын харьяат болох санал тавьсан Япон болон Хятад хоёр иргэний өргөдлийг шинжлэхүй (1947, 1972 он)”, *Historia Mongolarum* Tom. XX, Fasc. 8, 2021, 158-168

засаглалтай улс болсны дараа л харьяатын талаарх асуудалд анх удаа эрх зүйн зохицуулалт хийсэн байна. 1926 онд гадаадын харьяатуудыг зохицуулах “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад Явдлын Яамнаас тус улсын хязгаарын дотор суугаа гадаад улсын харьяат, өөр асуудлыг дагуулан авах тухай тогтоосон дүрэм”¹¹ гаргажээ. Уг дүрэмд гадаадын харьяатууд хилээр нэвтрэх, зорчих, амьдрах эрх авах тухай огтхон ч дурдаагүй байгаа бөгөөд зөвхөн харьяат болгон авах тухай зааж өгсөн байна. Энэхүү дүрмийн эхний зүйлд “Манай монгол улс тус улсын нутагт суугаа гадаад улсын харьяат, өөр асуудлын дотроос дагаар орохыг хүсэгчдийн шударга, самууныг ялгаж салгаж уул газар оронд харшдах үгүй бол дагуулан авч болмой” гэж заасан байгаа бөгөөд үүний доор тодорхой шаардлагуудыг тайлбарлан бичжээ.

1. Монгол улсад өөрийн хөрөнгийн хамт удаан хугацаанд амьдарч байгаа
2. Улс төрийн ямар нэгэн хэрэг хийгээгүй болоод сууж буй нутгийн монголчууд лугаа найрамдалтай сууж байгаа.
3. Монголд таваас багагүй жил сууж байгаа, Монгол эхнэр авч хүүхэдтэй болсон гадаадын иргэнийг түр саналаар дагуулан авна.

Энэ дүрэмд үндэс угсаа, шашин, ёс заншлын талаар огтхон ч дурдаагүй байгаа бөгөөд улс төрийн гэмт хэрэг үйлдээгүй, мөн монголд таваас доошгүй жил өөрийн хөрөнгийн хамт амьдарч, монгол эхнэр авч хүүхэдтэй болсон байх гэсэн шаардлагуудыг тавьж байжээ. Тус дүрмээр харьяатаар авах эцсийн шийдвэрийг БНМАУ-ын Гадаад Явдлын Яамнаас гаргахаар заажээ.

1935 онд БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс гадаадын харьяаттай холбоотой “Гадаадын харьяат нар БНМАУ-д нэвтрэн орох ба суух хийгээд, нэвтрэн гарах тухай”¹² 4 бүлэг, 18 зүйлтэй дүрмийг гаргасан байна. Гэвч энэхүү дүрэмд зөвхөн гадаадын иргэд хилээр хэрхэн нэвтрэх, хилээр гарах, түр оршин суух үнэмлэх, виз болон татвар, торгуулийн хэмжээний тухай дурдсан байгаа бөгөөд харин харьяат болгон авах тухай огтхон ч дурдаагүй байна.

1941 оны 1-р сарын 13-нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас “Гадаад улсын харьяат нараас БНМАУ-д дагаар орохыг хүсэгчдийг оруулан авах тухай дүрэм”-ийг гаргасан байна.¹³ Дайн дууссаны дараа БНМАУ-руу зүглэн ирэх монголчуудад зориулсан эрх зүйн орчныг тус дүрмээр бэлдэж байсан ч байж болох юм. Тус дүрмийн эхний зүйлд “БНМАУ-ын нутаг хязгаарын дотор оршин буй гадаад аль ч улсын харьяат ямар ч яс үндэстний хүмүүс БНМАУ-ын харьяат болж дагаар орох явдлыг чөлөөтэй байлгамуй” гэсэн байгаа бөгөөд харьяат болохыг хүсэгч гадаадын харьяат иргэн анкет бөглөдөг болжээ. Тус анкетад овог нэр, нас, хүйс, үндэс язгуур, хэдэн онд хаана төрсөн, одоо ямар ажил хөдөлмөр эрхэлдэг, өмнөх нутагт байсан тухай мэдээлэл, БНМАУ-д хаагуур, хэзээ орж ирсэн, одоо ямар ажил төрөл эрхэлдэг, гэр бүлийн байдал, цэрэгт явсан эсэх, ял шийтгэл эдэлж байсан эсэх, монгол улсад ямар учраас дагаар орохыг хүссэн

¹¹ Нэргүй, Ц. Золзаяа, Н. Мэндсайхан, Х. *Монголын харьяат, цагаачлалын түүх (нэн эртнээс-1922 он хүртэл)*, Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК, 2006, 298

¹² МУУТА Х.11, Д.1, ХН. 310

¹³ МУУТА Х.11, Д.1, ХН. 523

шалтгааны мэдээллийг бөглүүлэн авдаг болсон байна. Үүнээс харахад энэ үеэс эхлэн БНМАУ харьяат болохыг хүссэн гадаадын иргэнийг маш их судалж харьяат иргэн болгодог байсан нь харагдаж байна.

1959 онд 1-р сарын 16-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс “Гадаадын иргэнийг БНМАУ-ын иргэн болгох тухай заавар”-ыг гаргажээ.¹⁴ Уг зааврын 4-р зүйлд БНМАУ-ын иргэн болохыг хүсэгч гадаадын иргэн өөрийн хүсэлтээ БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын нэр дээр өргөдөл гарган өгөх бөгөөд өргөдөл, анкетад өөрийн 3 үеийн товч түүх, БНМАУ-д төрөөгүй бол түүхээ бичихдээ БНМАУ-д ирэхийн өмнөх үе ба ирснээс хойших үеийг бичих, одоогийн аж амьдрал, гэр бүлийн байдал, БНМАУ-ын иргэн болохыг хүссэн шалтгаан, өөрийн хамт БНМАУ-ын иргэн болохыг хүсэж байгаа насанд хүрээгүй хүүхдийн тодорхойлолтыг өргөдөлд бичүүлж авдаг болжээ. Энэхүү зааврын ёсоор харьяат болгох эцсийн шийдвэрийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид гаргах болжээ. Харьяат болохыг хүссэн хүнийг олон нийтийн хурлаар оруулан, өргөдөл, мэдээлэл нь засаг захиргааны бүх нэгжээр хянан шалгагддаг байсан ч эцсийн шийдвэрийг үргэлж төрийн эрх барих дээд байгууллагууд гаргаж байсныг харж болно.

1974 оны 12-р сарын 30-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 369-р зарлигаар “Гадаадын харьяатын тухай хууль”-ыг баталсан байна.¹⁵ Энэхүү хууль нь 13 зүйлтэй бөгөөд уг хуулийн 6-р зүйлд “БНМАУ-ын харьяат болохыг хүсэгч өөр улсын харьяат буюу харьяалалгүй иргэнийг эрэгтэй, эмэгтэй, арьс, үндэс, шашин шүтлэгээр ялгаварлахгүй БНМАУ-ын харьяат иргэн болгоно” гэж заажээ. Мөн харьяат болгон авах эцсийн шийдвэрийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн гаргахаар заажээ. Уг хуульд нэгэн сонирхолтой заалт шинээр оруулсан нь “Эцэг эхийн аль нэг нь л БНМАУ-ын харьяат байвал гадаадад төрсөн, мөн гадаадаас үрчилж авсан харьяалалгүй хүүхэд нь БНМАУ-ын иргэн болж болно. Мөн БНМАУ-ын нутаг дэвсгэрээс олдсон эцэг эх нь тогтоогдоогүй хүүхэд БНМАУ-ын харьяат болж болохоор” заасан байна. Урадын Булаг үүнийг “Монгол улс хүн ам цөөтэй тул Засгийн газраас нь *эрлийз* хүний Монголын иргэншлийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг байжээ”¹⁶ гэж бичжээ.

1980-аад оноос БНМАУ хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эмхэтгэн цэгцэлж системчлэх 5 жилийн төлөвлөгөөт ажил явагдаж, үүний дагуу 1974 оны БНМАУ-ын харьяатын тухай хуулийг 1987 онд Шүүх яам, Гадаад Явдлын Яам хамтран шинэчлэн боловсруулжээ.

Бидний судалж буй 1961-1990 оны үеийн 1961-1974 оны үеийг 1959 оны “Гадаадын иргэнийг БНМАУ-ын иргэн болгох тухай заавар”-аар, 1974-1987 оны үеийг 1974 оны БНМАУ-ын харьяатын тухай хуулиар, 1987-1990 оны үеийг 1987 оны шинэчилсэн БНМАУ-ын харьяатын тухай хуулиар шийдэж байв.

¹⁴ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл (1941-1970), Хоёрдугаар дэвтэр, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1974, 276

¹⁵ МУУТА Х.11, Д.2, ХН. 1394

¹⁶ Булаг, Э. *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*, Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар, 2016, 144

Мөн 1926 оны гадаадын харьяатын тухай дүрмээс бусад бүх хууль, дүрмүүдэд харьяат болгон авахад тавигдах шаардлага байхгүй, гагцхүү хүний язгуур үндэс, харьяаллыг ялгаварлахгүй, өөрсдийн хүсэлтээр БНМАУ-ын харьяат болж болно гэж заасан байдаг. Судлаач Ш.Гэрэлийн судалгаанд “Өгүүлэн буй үед (тус үе нь 1940-өөд оны сүүл үе) мөрдөж байсан Гадаадын харьяат хүн Монгол Улсын иргэн болох тухайд баримталж байсан шалгуурууд ч Япон эрийн байдалд нийцэхгүй байв. Учир нь тус улсын харьяат болохын тулд Монголд 10-аас доошгүй жил оршин суусан, ажил хөдөлмөр эрхэлдэг байх, мөн монгол бүсгүйтэй гэрлэсэн байвал харьяат болох асуудлыг авч хэлэлцдэг байв”¹⁷ хэмээн бичжээ. Гэвч 1941 оны дүрэмд ийм шалгуур огт байхгүй бөгөөд ийнхүү авч хэлэлцдэг байсныг баримтаар нотлолгүй таамаглан бичсэн бололтой. Ямартай ч бидний судалгааны дүгнэлтээр 1941 оноос хойших гадаадын харьяатын тухай дүрэм, хуулиуд нь зөвхөн социалист интернационалч үзлийн хүрээнд бичигдсэн, өнгөн далдлалт маягийн эрх зүйн зохицуулалт байсан бөгөөд БНМАУ гадаадын иргэдийг харьяат болгон авахдаа үндэсний үзэл шингээн, тухайн хүний үндэс язгуурыг харгалзан авч үздэг байжээ.

1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын тоо, харьяалал, үндэс угсаа

1961-1990 оны хооронд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1961 оны 1-р сарын 6-аас 1990 оны 8-р сарын 17 хүртэлх 182 удаагийн зарлигаар нийтдээ 1,031 хүнийг БНМАУ-ын харьяат болгон авчээ. Энэхүү нийт тоог 1940-1965 онд БНМАУ-д дагаар орогчдын оны дүнгээр гаргасан товчоон¹⁸, 1961-1980 оны хооронд БНМАУ-ын харьяат бологчдын бүртгэл¹⁹ болон 1961-1990 оны хоорондох Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан зарлигуудыг²⁰ шүүж, боловсруулан гаргаж ирсэн болно.

Нийт харьяат бологсдын тоо бага мэт харагдаж байвч БНМАУ-д ажиллаж, амьдарч байсан гадаадын иргэд болон цагаач иргэдийн тоог харвал тийм биш нь харагдах болно. Жишээлбэл: 1969 оны хүн амын тооллогоор БНМАУ-д 27,113 гадаадын харьяат иргэн ажиллаж, амьдарч байжээ.²¹ Харин 1979 онд БНМАУ-д 56,546 гадаадын харьяат цагаач иргэн ажиллаж, амьдарч байсан байна.²² БНМАУ-ын харьяат болохыг хүссэн нийт хэчнээн өргөдөл, хүсэлт ирж байсан тухай тоо баримт байхгүй боловч БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ажиллаж, амьдарч байсан эдгээр гадаадын иргэдийн тооноос харвал БНМАУ гадаадын иргэдийг харьяат болгон авахдаа хатуу чанга шаардлага тавьдаг байсан нь харагдаж байна.

¹⁷ Гэрэл, Ш. “БНМАУ-ын харьяат болох санал тавьсан Япон болон Хятад хоёр иргэний өргөдлийг шинжлэхүй (1947, 1972 он)”, Historia Mongolarum Tom. XX, Fasc. 8, 2021, 163

¹⁸ МУУТА Х.11, Д.3, ХН. 409

¹⁹ МУУТА Х.11, Д.3, ХН. 551

²⁰ 1961-1990 оны Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигууд


²¹ Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд, Улаанбаатар: Үндэсний Статистикийн газар, 2003, 27

²² Мөн тэнд, 27

Мэдэгдэж буй баримтаар нийт харьяат болсон 1,031 хүний 318 нь БНХАУ-ын харьяалалтай, 7 нь ЗХУ-ын харьяалалтай, 587 нь аль ч улсын харьяалалгүй, 119 хүний харьяалал нь тодорхойгүй байна. Харин аль ч улсын харьяалалгүй 587 иргэний 143 нь БНХАУ-ын харьяат байж байгаад гарсан, 31 нь ЗХУ-ын харьяат байж байгаад гарсан, 413 хүний өмнөх харьяаллын мэдээлэл тодорхойгүй байна. БНХАУ-ын харьяат байгаад аль ч улсын харьяат биш болсон хүмүүсийн дийлэнх нь 1972-1974 оны хооронд БНХАУ-ын харьяаллаас татгалзсан байна.

Эдгээр иргэдийг яс үндсээр нь ялгавал өвөр монгол 587, хятад 249, орос 26, халх 11, буриад 28, казах 10, солонгос 1, узбек 3, уйгур 3, үндэс угсаа нь тодорхойгүй 113 хүн байна. Өвөр монголчууд дотор 159 хүний үндэс угсаа нь нарийн мэдэгдэж байгаа бөгөөд үүнд авга 2, алшаа 8, барга 15, горлос 2, дагуур 12, дөрвөд 2, ордос 2, өөлд 8, сөнөд 12, торгууд 1, түмэд 9, уйгур 1, урианхай 2, үзэмчин 10, харчин 4, хорчин 55, хуучид 2, цахар 12 хүн байна.

1961-1990 онд БНМАУ-ын харьяат иргэн болсон иргэдийн тал нь БНХАУ-ын иргэн, талаас илүү хувь нь Монгол үндэстний хүмүүс байсан нь тодорхой харагдаж байна. Мөн үндэс угсаа нь тодорхойгүй хүмүүсийн нэрийг харвал монгол, төвөд нэр зонхилж байх бөгөөд эдгээр иргэд монгол угсаатны хүн байсан гэж үзвэл 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат иргэн болсон хүмүүсийн 70 гаруй хувийг монгол үндэс, угсааны хүмүүс эзэлж байжээ.



Хүснэгт 1: 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдыг үндэс угсаагаар нь ялган харуулсан хүснэгт

1961 болон 1962 онд хамгийн их гадаадын иргэн БНМАУ-ын харьяат иргэн болсон байгаа бөгөөд уг үеэс харьяат иргэн бологсдын тоо тасралтгүй буурч байгаад 1980-аад онд хамгийн доод цэгтээ хүрч, 1980-аад оны зарим онуудад харьяат иргэн огт аваагүй байна. 1988 оноос Монгол, Хятадын харилцаа сэргэхтэй зэрэгцэн дахин өссөн байна.

1960-аад оноос Зөвлөлт, Хятадын харилцаа хүйтэрсэн нь БНМАУ-ын гадаад харилцаанд шууд нөлөөлж, гадаадын иргэнийг харьяат болгох тоо ч дагажээ.


1955-1964 онд БНХАУ нь БНМАУ-ын социалист бүтээн байгуулалтад туслуулахаар олон мянган хятад ажилчин илгээж, эрчим хүч, хөдөө аж ахуй, зам тээвэр, хөнгөн үйлдвэр, орон сууцны олон арван барилга байгууламж барьж ашиглалтад оруулсан билээ. 1955-1964 онд Монголд ажиллаж байсан нийт хятад ажилчдын тоо 17-18 мянгад хүрч, хятад эмнэлэг, сургууль хүртэл ажиллуулж байв. Гэвч нэгэн сонирхолтой зүйл байгаа нь 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат иргэн болсон хятадууд нь эдгээр хятад ажилчид биш байгаа юм. 1961 оны байдлаар хятад ажилчдаас 4 хүн харьяат болсон²³ байгаа бөгөөд 1964 оны байдлаар 12 хүн гэр бүл зохиож амьдрахаар үлдэж, бусад нь бүгд буцжээ.²⁴

1961 онд 77, 1962 онд 122 хятад хүнийг БНМАУ-ын харьяат иргэн болгон авч байсан бол 1963 оноос энэ тоо илт багасаж, 1976 оныг хүртэл нийт 49 хятад хүнийг харьяат болгон авчээ. Мэдэгдэж буй баримтаар 1976-1989 он хүртэл нэг ч хятад хүнийг БНМАУ-ын харьяат иргэн болгож аваагүй байна.

1980 оноос эхлэн БНМАУ гадаадын иргэдийг харьяат болгон авах нь илт багасжээ. 1981, 1983, 1987 онуудад ямар ч иргэнийг харьяатаар аваагүй байна. Энэ нь мөн л Монгол, Хятадын харилцаатай шууд холбоотой. Монголын Засгийн газар 1979-1983 оны хооронд 8,000 гаруй хууль бусаар амьдрагч цагаач хятадуудыг хөөж гарган, БНХАУ-тай харилцах харьцаагаа бүрмөсөн тасалж байв.²⁵ Энэ үйл явдал нь 1980-аад оны БНМАУ-ын харьяат бологсдын тоонд шууд нөлөөлжээ.

1979 оны байдлаар БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ЗХУ-ын харьяат нийт 49,223 иргэн амьдарч байсан²⁶ бөгөөд үүнээс маш өчүүхэн хэсэг БНМАУ-ын харьяат иргэн болсон нь 1971 оны 1-р сарын 26-нд баталсан ЗХУ, БНМАУ-ын хооронд байгуулсан Иргэд харилцан визгүй зорчих журмын тухай хэлэлцээртэй²⁷ шууд холбоотой гэж үзэж байна. Буриадууд бага тоогоор харьяат болсон нь нөгөө талаар ЗХУ-ын хүн ам зүйн бодлого байсан байж магадгүй юм.

Хүснэгт 2: 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын нийт тоог оноор үечлэн харуулбал



²³ Наранжаргал, Д. *Хятад ажилчид БНМАУ-д (1949-1964)*, Улаанбаатар: Сэлэнгэ Пресс, 2019, 138

²⁴ Мөн тэнд, 146

²⁵ Булаг, Э. *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*, Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар 2016, 16

²⁶ *Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд*, Улаанбаатар: Үндэсний Статистикийн газар, 2003, 25

²⁷ *Монгол Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1978)*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1981, 417

БНМАУ-ын харьяат бологсдын хүйс

Нийт харьяат бологсдоос 471 хүний хүйс мэдэгдэж байна. Үүний 334 нь эр, 137 нь эмэгтэй байна. Харин хүйсийн мэдээллийг үндэс угсаагаар нь ангилан харвал эрэгтэйчүүдээс өвөр монгол 263, хятад 39, орос 3, буриад 10, узбек 3, уйгур 3, халх 6, үндэс угсаа нь тодорхойгүй 7 байна. Эмэгтэйчүүдээс өвөр монгол 104, хятад 5, орос 6, буриад 13, солонгос 1, халх 5, тодорхойгүй 3 байна. Энэхүү баримтаас харвал БНМАУ гадаадын иргэдийг харьяат болгон авахдаа эрэгтэй хүйсийг түлхүү харгалзан үздэг байсан бололтой.

БНМАУ-ын харьяат бологсдын нас


Нийт харьяат бологсдоос 458 хүний нас мэдэгдэж байна. Насны хувьд ангилан харвал 0-20 насны 136 хүн, үүний 84 нь өвөр монгол, 3 нь хятад, 1 нь орос, 8 нь буриад, 4 нь халх, 21-40 насны 77 хүн, үүний 45 нь өвөр монгол, 6 нь хятад, 3 нь орос, 7 нь буриад, 5 нь халх, бусад 1, үндэс угсаа тодорхойгүй 7 хүн байна. 41-60 насны 187 хүн, үүний 156 нь өвөр монгол, 13 нь хятад, 3 нь орос, 7 нь буриад, 2 нь бусад, 2 нь халх, 2 нь тодорхойгүй, 61-85 насны 58 хүний 43 нь өвөр монгол, 11 нь хятад, 1 нь орос, 3 нь бусад үндэс угсаатай хүмүүс байна. Мэдэгдэж буй баримтаас харьяат болсон иргэдийн ихэнх нь 41-60 насны хүмүүс байгаа бөгөөд энэхүү үеийг дотор нь нарийн ангилбал 41-45 насны 55 хүн, 46-50 насны 54 хүн, 51-55 насны 36 хүн, 56-60 насны 42 хүн байна. Энэхүү тооноос харвал өвөр монголчуудыг харьяат болгон авахдаа түлхүү залуу хүмүүсийг, харин хятад иргэдийг харьяат болгон авахдаа 40-ээс дээш насныхныг түлхүү авч байсан нь харагдаж байна.

Хүснэгт 3. 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын насыг үндэс угсаа, хүйсээр нь ангилан харуулбал

Нас	Нийт	Үндэс													
		Өвөр монгол		Хятад		Орос		Буриад		Бусад		Халх		Тодорхойгүй	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
0-20	136	52	32	1	2	1		2	6			3	1		
21-25	17	4	6	1			1	1	1				1	Т	1
26-30	16	2	4	1			2		1				2		2
31-35	22	6	7	2	2			1		1		2			
36-40	22	10	6					2	1						3
41-45	55	39	7	4			1					1		2	
46-50	54	37	8	2			1	2	3	1					
51-55	36	27	4	3		1			1						
56-60	42	29	5	4				1		1		1			
61-70	41	26	6	6		1				2					
71-85	17	5	6	4	1					1					
Нийт	458	237	91	28	5	3	5	9	13	6		6	5	6	3

1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын байршлын мэдээлэл

Нийт харьяат бологсдоос 937 хүний байршлын мэдээлэл тодорхой байна. Үүнд Улаанбаатар хотоос 573, Архангай аймгаас 1, Баян-Өлгий аймгаас 1, Баянхонгор аймгаас 6, Булган аймгаас 87, Дархан хотоос 11, Дорноговь аймгаас 38, Дорнод аймгаас 45, Завхан аймгаас 7, Өвөрхангай аймгаас 2, Өмнөговь аймгаас 21, Сүхбаатар аймгаас 10, Сэлэнгэ аймгаас 39, Төв аймгаас 56, Увс аймгаас 4, Ховд аймгаас 12, Хөвсгөл аймгаас 2, Хэнтий аймгаас 19, Эрдэнэт хотоос 2 хүнийг БНМАУ-ын харьяат иргэн болгон авчээ. Байршил нь тодорхойгүй 86 хүн байна.



Зураг 1. 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын байршил

Нийт харьяат бологсдын талаас илүү хувийг Улаанбаатар хотоос авчээ. 1961 онд хөдөө орон нутгийн гадаадын иргэдийг ихэвчлэн харьяат болгон авч байсан бол 1962 оноос эхлэн түлхүү Улаанбаатар хотод оршин сууж байсан гадаадын иргэдийг харьяат болгон авч эхэлжээ.

1961-1966 оны хооронд нийт 313 хүнийг Улаанбаатар хотоос харьяат болгон авсан байгаа бөгөөд үүний 137 нь өвөр монгол, 151 нь хятадууд, 17 нь оросууд, 6 нь буриад, үлдсэн хүмүүсийн үндэс угсаа нь тодорхойгүй байна. Байршлаар нь нарийн ангилбал дээрх өвөр монголчуудын 11 нь Ажилчны хороонд, 4 нь Амгалангийн хороонд, 6 нь Зүүн сэлбийн хороонд, 12 нь Найрамдлын хороонд, 4 нь Налайх хотод, 7 нь Октябрийн хороонд, 4 нь Сүхбаатарын хороонд, 23 нь Толгойтын хороонд, 15 нь Төмөр замын хороонд, 3 нь Уурхайчдын хороонд, 9 нь Хоршооллын хороонд, 25 нь Чингэлтэйн хороонд, 14 нь Чойбалсангийн хороонд байрлаж байв. Харин хятадуудын 10 нь Ажилчны хороонд, 10 нь Амгалангийн хороонд, 27 нь Зүүн сэлбийн хороонд, 15 нь Найрамдлын хороонд, 2 нь

Налайх хотод, 8 нь Сүхбаатарын хороонд, 1 нь Толгойтын хороонд, 3 нь Төмөр замын хороонд, 3 нь Уурхайчдын хороонд, 17 нь Хоршооллын хороонд, 36 нь Чингэлтэйн хороонд, 19 нь Чойбалсангийн хороонд байрлаж байв. Үүнээс харвал өвөр монголчуудын дийлэнх нь Улаанбаатар хотын баруун талд, хятадуудын дийлэнх нь хотын зүүн талд, харин Чингэлтэй, Чойбалсангийн хороонд хольцолдон сууж байсан нь харагдаж байна. Харин оросуудын хувьд Чингэлтэйн хороо, Төмөр замын хороонд, буриадууд Налайх хотод түлхүү сууж байжээ.

1966-1990 оны хооронд нийт 261 хүнийг Улаанбаатар хотоос харьяат болгон авсан бөгөөд үүний 205 нь өвөр монгол, 13 нь хятад, 6 нь орос, 16 нь буриад, үндэс угсаа нь тодорхойгүй 8 хүн байна. Өвөр монголчуудын 39 нь Ажилчны районд, 31 нь Найрамдлын районд, 1 нь Налайх хотод, 49 нь Октябрийн районд, 78 нь Сүхбаатарын районд сууж байв. Харин хятадуудын 1 нь Ажилчны районд, 5 нь Октябрийн районд, 6 нь Сүхбаатарын районд байрлаж байжээ. Харин орос, буриадууд ихэвчлэн Найрамдлын болон Сүхбаатарын районд байрлаж байсан байна.

Харин хөдөө орон нутгаас төв, зүүн бүсийн нутаг буюу Булган, Төв, Сэлэнгэ, Дорноговь, Дорнод аймгаас ихэнх харьяат бологчдыг авчээ. Булган аймгаас харьяат болсон 88 хүний 34 нь өвөр монгол, 48 нь хятад, халх 1, буриад 3, Төв аймгаас харьяат болсон 56 хүний 46 нь өвөр монгол, 8 нь хятад, Сэлэнгэ аймгаас харьяат болсон 39 хүний 31 нь өвөр монгол, 4 нь хятад, 1 нь буриад, Дорноговь аймгаас харьяат болсон 38 хүний 33 нь өвөр монгол, 3 нь хятад, 1 нь орос, Дорнод аймгаас харьяат болсон 45 хүний 36 нь өвөр монгол, 7 нь хятад хүмүүс байна. Үүнээс харвал хөдөө орон нутгаас ганцхан Булган аймгаас хятадуудыг ихээр харьяат болгон авсан байгаа бөгөөд бусад аймгуудаас өвөр монголчуудыг ихээр харьяат болгон авчээ. Энэ нь БНМАУ-ын хүн ам зүйн бодлогын нэг хэсэг байжээ.

1961-1990 онд БНМАУ-ын харьяат бологсдын гэр бүлийн байдал

1966 оноос өмнө нэг байршилд буй олон гадаадын иргэдийг нэг тушаалаар бөөнөөр нь харьяат болгон авч байв. 1966 оноос хойш энэ байдал өөрчлөгдөж, бөөнөөр нь харьяат болгох авах тушаалыг ихэвчлэн гэр бүлээр нь авахад гаргадаг болжээ. 1961-1990 оны хооронд нийт 19 хүн 49 хүүхдийнхээ хамтаар БНМАУ-ын харьяат иргэн болсон байна.

БНМАУ-ын хилээр эхнэр болон нөхөр, гэр бүлийн хамтаар орж ирсэн нь мэдэгдэж буй 7 өвөр монгол, 1 хятад байна. Харин хилээр ганцаар орж ирэн БНМАУ-ын иргэнтэй гэр бүл болсон нийт 27 иргэн байгаа бөгөөд үүний 23 нь өвөр монгол, 3 нь буриад, 1 нь хятад иргэн байна. Эдгээр иргэд БНМАУ-ын иргэнтэй гэр бүл болон дунджаар 5 хүүхэдтэй болж байв. БНМАУ-ын иргэнтэй гэр бүл болсон гадаадын харьяат иргэдийн 24 нь эрэгтэй, 3 нь эмэгтэй байна. Мөн эдгээр иргэд хилээр орж ирснээсээ хойш 2-5 жилийн дараа гэр бүлтэй болж байжээ.

1990 онд БНМАУ-ын харьяат болсон иргэдийн өргөдөл дээр *“Идээшин дассан энэ нутагт үр хүүхдүүдээ бараадан амьдрах хүсэлтэй байгаа тул.....Үр хүүхдүүдээ түшиглэн амьдрах хүсэлтэй байгаа тул.....Үр хүүхдүүдийнхээ*

асрамжид амьдрах хүсэлтэй байгаа тул...,...эцэг өвгөдийнхөө төрж өссөн энэ нутагт эхнэр үр хүүхдийн хамт амьдрах хүсэлтэй тул БНМАУ-ын харьяат болгож өгнө үү” гэх мэтчилэн бичжээ. Магадгүй БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр төрсөн гадаадын иргэний “БНМАУ-ын харьяат иргэн” хүүхэд нь тухайн хүнийг харьяат иргэн болгон авах бас нэгэн том шалгуур байсан байж болох юм.

БНМАУ-ын харьяат бологсдын БНМАУ-ын нутаг дэвсгэрт анх нэвтэрсэн он цаг, шалтгаан

Нийт харьяат бологсдоос 212 хүн БНМАУ-д хэзээ орж ирсэн нь мэдэгдэж байна. Эдгээр хүмүүсийн орж ирсэн он цаг нь тухайн үеийн нийгэм, цаг үеийн нөхцөл байдалтай шууд хамааралтай тул уг мэдээллээр бусад хэзээ орж ирсэн нь тодорхойгүй байгаа харьяат иргэн бологсдыг төлөөлүүлэн авч үзвэл буруудахгүй болов уу.

Хэзээ орж ирсэн нь мэдэгдэж буй харьяат иргэн бологсдын дийлэнх нь 1945 он, 1956-1961 он, 1962-1968 оны хооронд БНМАУ-руу масс шилжилт хөдөлгөөн хийсэн байна.

1915-1944 оны хооронд БНМАУ-ын хилээр нэвтэрч орж ирсэн 20 хүн байна. Үүний 7 нь өвөрмонгол, 7 нь хятад, 3 нь буриад, 1 нь орос, 2 нь халх байна. Үүний 7 нь хувийн хэргээр, 1 нь амьдрахын тулд, 1 нь мал хариулж байгаад төөрөлдсөн, 1 нь малын зам хянагчийн ажлаар орж иржээ. Үүнээс 1915-1944 оны хооронд нааш чиглэсэн шилжилт хөдөлгөөн тийм ч их биш байсныг харж болно.

Нийт харьяат болсон иргэдээс хэзээ орж ирсэн нь мэдэгдэж байгаа 12 хятад хүний мэдээлэл байгаа бөгөөд бусдыг нууцалсан байж болох юм. Эдгээр иргэдийн 7 нь 1915-1928 оны хооронд, үлдсэн нь 1939-1958 оны хооронд орж иржээ.

1945 онд харьяат бологсдоос 99 хүн БНМАУ-д орж иржээ. Үүний 96 нь өвөр монголчууд, 2 нь хятад, 1 нь узбек байна. Эдгээр хүмүүсийн 9 нь сайн дураараа амьдрахаар, 42 нь хувийн хэргээр, 12 нь Дэ вангийн цэрэгтэй хамт, 1 нь суралцах зорилгоор, 1 нь олзлогдон орж иржээ.

БНМАУ-ын хувьд тусгаар тогтнолоо олон улсад хүлээн зөвшөөрүүлэхийн зэрэгцээ мөн Японы эсрэг дайнд оролцсон нэгэн гол шалтгаан нь Монголын удирдагчид өвөр монгол, баргыг нэгтгэх, нэгдсэн Монгол улс байгуулах давхар зорилготой байсан билээ. 1945 оны 8-р сарын 10-нд БНМАУ-аас Японд дайн зарлах тухай тунхаглалыг Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч С. Лувсан уншиж танилцуулжээ. Үүний дараа маршал Х.Чойбалсан радиогоор үг хэлж, тус дайнд монголчууд яагаад орох болсон талаар дурдаад “*Бид Японы түрэмгийлэн эзлэгч нарыг бут цохисны эцэст бүх монголчуудыг эрх чөлөөтэй, тусгаар тогтносон, бүрэн эрхт нэгэн ах дүү улс гэр бүл болгон нэгдүүлэх явдлыг хангах болно*” гэжээ.²⁸ Мөн оны мөн өдөр хэвлэгдсэн “Намын үнэн” сонинд: “*Япон манай төрөл садан дотоод монголчуудыг боолын боол, босгоны шороо болгогч.*

²⁸ Урангуа, Ж. *Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан Япончууд*, Улаанбаатар: 2018, 46

Дотоод Монгол манай Монгол улс лугаа нэгдэж, нэгэн гэр улс болохыг 1911 онд илэрхийлж байсан боловч тэр цагтаа эрх бээр бид нэгэн үндэсний монголчууд нэгдэж чадсан үгүй. Одоо тэд Японы гарт орон элдвээр дарлагдан зовж байна. Энэ завсар манай Монгол улс чийрэг чадмаг болсон тул Зөвлөлт ах дүү нартаа өршөөлт сэтгэлээ илэрхийлж, авралт гараа сунгах цаг болов” гэсэн байсан бол “Залуучуудын үнэн” сонинд Дотоод Монголд манай цэрэг хэрхэн амжилттай давшиж байгаа талаар байнга мэдээлж, “Монгол овогтон нэгдэн суухын ерөөл” гэх нийтлэл хэвлэгдэн гарчээ.²⁹

Гэвч дайн дууссаны дараа өвөр монголыг өөртөө нэгтгэж чадахгүй болсныг ойлгосон Чойбалсан өвөр монголчуудыг Монголд ирж амьдрахыг уриалж байжээ. Энэхүү уриалгын дагуу эсвэл тухайн нийгмийн байдлаас болж хавчигдан амьдрахын эрхээр, ялангуяа Баргаас олон айл зохион байгуулалттайгаар нүүдэллэн ирж суурьшсан байна. 1946 онд нийт 3,864 өвөр монгол БНМАУ-ын харьяат болсон³⁰ байгаа нь тус үед олон монголчууд БНМАУ-руу чиглэсэн чиглэсэн шилжилт хөдөлгөөн хийснийг харуулж байна.

Шилжилт хөдөлгөөний дараагийн үе нь 1956-1961 оны хооронд байна. Энэ үе нь БНМАУ-ын гадаад харилцааны хамгийн таатай үе бөгөөд энэ хооронд харьяат иргэн бологсдоос 48 хүн БНМАУ-д орж ирсний 41 нь өвөр монгол, 2 нь хятад, 4 нь буриад, 1 нь тодорхойгүй байна. Мөн энэ үеэс БНМАУ-д суугаа гэр бүлийн хэн нэгний урилгаар амьдрахаар ирэх хүмүүс ихэссэн байна. 1956-1961 оны хооронд БНМАУ-ын харьяат болсон хүмүүсийн 25 нь хувийн хэргээр, 8 нь урилгаар, 3 нь амьдрахаар, 9 нь эцэг эхийгээ даган орж ирсэн байна.

1953 он болоход БНХАУ-ын гадаад бодлого хэвийн байсан ч дотооддоо их хэлмэгдүүлэлтийн бэлтгэл ажлыг хийж байлаа. 1953 он болоход хувьсгалын эсэргүүцэгчийг арилгах нэртэй хөдөлгөөн өрнөж, хуучин нийгмийн эрх баригчдыг баривчлан цаазалж эхэлжээ. Залгаад 1957 оноос сэхээтнийг цэвэрлэж арилгах Баруунтныг эсэргүүцэх хөдөлгөөнийг эхлүүлжээ. Энэхүү хөдөлгөөний дүнд БНХАУ-ын 120 мянган орчим сэхээтэн нийгэм журамт нийгмийг эсэргүүцсэн хэргээр хэлмэгджээ. БНХАУ-ын засгийн газрын гаргасан материалыг үндэслэвэл өвөр монголд 3,934 хүн баруунтан болсон байна. 1958 оноос ардын нэгдэл байгуулагдан монголчууд ч хамрагдаж эхэлжээ. Хувийн өмчийг хураан авч, улсын өмч болгож байв.³¹ Ийнхүү өвөр монголчуудын амь зогоох малыг улсад хураан авч эхэлжээ. 1958 оноос хүчээр эхлүүлсэн ардын нэгдлийг байгуулах төрийн бодлого нь ялагдсанаар 1962 он хүртэл бүх Хятад улсад 36 сая хүн өлбөрч үхжээ. Мөн амуу тариа будааг шийдвэрлүүлэхийн тулд цэргээс халагдсан хятадуудаар голлосон улсын атар хагалбарлах анги нь Хөлөнбуйрын тал нутагт атар хагалбарлах төлөвлөгөө гаргаж байжээ. Хятадуудын нүдэнд тэнэгэр уудам тал нутагт цөөн тооны монгол хүн амьдрах нь их “хөнөөлтэй” санагдаж байв.³² Энэ мэтчилэн БНХАУ-ын дотоодын бодлого нь ямагт өвөр

²⁹ Мөн тэнд, 47

³⁰ МУУТА. Х.11, Д.3, ХН. 409

³¹ Огонус Цогту, *Монгол хүн ба соёлын хувьсгал*, Улаанбаатар: Монсудар, 2017, 58

³² Огонус Цогту, *Монгол хүн ба соёлын хувьсгал*, Улаанбаатар: Монсудар, 2017, 73-74

монголчуудыг шахах болж, үүнтэй зэрэгцэн БНМАУ өвөр монголчуудыг үргэлж нааш ирүүлэх бодлого барьж байлаа.

1956-1961 оны хоорондох дулаарлын үеийг ашиглан 1957 онд БНМАУ-д өвөр монголчуудыг их хэмжээгээр нүүлгэн авчрах тухай Монгол, Хятадын хэлэлцүүлэг болжээ.³³ Социалист интернационалч бодлогыг бүх шатанд барьж байсан ч Монгол Улс үндэстнээ нэгтгэх төрийн бодлогоо огтхон алдаагүй байсныг үүнээс харж болно. Харин өвөр монголчуудыг олноор БНМАУ-д нүүлгэн суулгах явдал бол БНХАУ-ын нэр хүндийг хөндөх явдал байсан учраас Мао Зе Дун тухайн үеийн БНМАУ-ын удирдлага Дамбад захидал илгээн, өвөр монголчуудыг нүүн суулгах асуудлыг эсэргүүцжээ. Эсрэгээрээ хятад хүнийг нүүлгэн суулгая гэж ярьсан байна. Энэхүү хэлэлцээр амжилтгүй болсон ч БНХАУ-ын дотооддоо явуулж байсан алдаатай бодлого нь өвөр монголчуудыг хэлэлцээртэй, хэлэлцээргүй БНМАУ-руу шилжилт хөдөлгөөн хийх маш том шалтгаан болж байжээ. Мөн энэ үед улс түмний найрамдал хамтач ажиллагааны шинэ үе эхэлсэн гэх шалтгаанаар 1950-аад оны эхээр Хилийн цэргийг татан буулгаж, хилийн пункт, байцаан өнгөрүүлэхүүдээр улсын хилийн дэглэм, журмыг сахиулж байсан³⁴ бөгөөд 1960-аад оны эх хүртэл БНМАУ хойд, өмнөд талаа энхийн хил болсныг зарлаж байв.³⁵ Энэ нь социалист интернационалч бодлого гэхээсээ илүүтэй үндэстнээ татан авчрах төрийн бодлого байсан байж болох юм.

Шилжилт хөдөлгөөний сүүлийн үе нь 1962-1969 оны хооронд тохиосон байна. Энэ хооронд БНМАУ-д харьяат бологсдоо 36 хүн орж ирсний 31 нь өвөр монгол, 1 нь хятад, 2 нь буриад, 1 нь халх, 1 нь уйгур байна. Мөн 1962 онд уг 36 хүний 13 нь орж ирсэн байна. Эдгээр иргэдийн 2 нь хувийн хэргээр, 3 нь амьдрах зорилгоор, 5 нь эцэг эхийнхээ хамтаар амьдрахаар орж ирсэн байна. Уг үед хил зөрчиж орж ирснээ мэдүүлсэн тоо ихэссэн бөгөөд нийт 12 хүн хил зөрчиж орж ирснээ мэдүүлжээ. Мөн 1972, 1977 онуудад тус тус 1 өвөр монгол хил зөрчиж орж ирсэн байгаа бөгөөд үүнээс өвөр монголчууд 1960-аад оноос хойш ч дүрвэж орж ирдэг байсныг харж болно.

Энэхүү шилжилт хөдөлгөөнд мөн л Монгол, Хятадын харилцаа нөлөөлсөн байна. 1966-1969 онд явуулсан БНХАУ дотооддоо Соёлын хувьсгал явуулж, олныг хамарсан хэлмэгдүүлэлт, аллага өрнөсөн билээ. Энэ нь өвөр монголчуудыг мөн л элэг нэгтэн рүүгээ зугтаах, дүрвэхэд хүргэжээ. 1960-1966 оны хооронд Өвөр монголд 160 удаагийн Улсаас урвасан хэрэг гарч, 624 хүн гадаадад дутаажээ.³⁶ Үүний ихэнх нь БНМАУ-руу дутаасан бололтой. Мөн 1960 оны үндсэн хуулийн 83-р зүйлд “Хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах, үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэх, энх тайвныг бэхжүүлэх хэрэгт зүтгэсэн буюу шинжлэх ухаан, улс төрийн үйл ажиллагааны улмаас хавчигдсан гадаадын иргэдэд БНМАУ-ын нутагт дэвсгэрт оршин суух эрх эдлүүлнэ”³⁷ гэж заасан

³³ Мөн тэнд, 350

³⁴ <https://bpo.gov.mn/aboutus/106/1206270005/detail>

³⁵ Батсайхан, О. нар. *Монголын түүх 1911-2017*, Улаанбаатар:Соёмбо Принтинг ХХК, 2018, 391

³⁶ Огонус Цогту, *Монгол хүн ба соёлын хувьсгал*, Улаанбаатар: Монсудар, 2017, 64

³⁷ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль, улс төр, эрх зүйн дэлгэрэнгүй тайлбар*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1988, 221

байна. Энэхүү оршин суух эрх эдлүүлнэ гэсэн нь нэг талаас улс төрийн үйл ажиллагааны улмаас мөрдөгдөж байгаа, улс төрийн үзэл бодол нийлэхгүй, байх бололцоогүй болсон хүн аливаа нэг улсад хорогдох тухай хүсэлт тавих эрх, нөгөө талаас тэрхүү улсын нутагт орох, оршин суух зөвшөөрөл олгох эрхийг багтаасан ойлголт³⁸ бөгөөд энэхүү шилжилт хөдөлгөөний үед БНМАУ нь “дайсан” улсынхаа улс төрийн үйл ажиллагааны улмаас хавчигдан, дүрвэсэн хүмүүсийг хуулийн дагуу орогноулдаг эрх зүйн орчинтой болсон байв.

1911-1989 онд хилийн гаднаас шилжин ирж суурьшсан хүмүүсийн тоо гарч явсан хүний тооноос бараг 10-аад дахин их байсан нь Монгол улсад хувь хүний амьдрах боломж хоёр хөршөөс илүү найдвартай, хяхал хавчлага харьцангуй бага байснаар тайлбарлагдана.³⁹

Одоо мөрдөгдөж буй харьяатын тухай хууль тогтоомжийн 9-р зүйлийн 2-д зааснаар “Монголын ард түмний ёс заншил, төрийн албан ёсны хэл, Монгол улсын үндсэн хуулийн талаар зохих мэдлэг эзэмшсэн ба иргэний харьяатын асуудлаар өргөдөл гаргасан өдрөөс өмнө Монгол улсын нутаг дэвсгэр дээр таваас доошгүй жил байнга оршин суусан байх”⁴⁰ гэж заасан байдаг. Харин 1941 онд гаргасан “Тадаад улсын харьяат нараас БНМАУ-д дагаар орохыг хүсэгчдийг оруулан авах тухай дүрэм”, 1959 оны гадаадын иргэдийг харьяат болгон авах заавар, 1974 оны БНМАУ-ын харьяатын тухай хууль, 1987 оны БНМАУ-ын шинэчилсэн харьяатын тухай хуулиудад БНМАУ-ын иргэн болохын тулд Монгол улсын нутаг дэвсгэр дээр тэдэн жил амьдарсан байх ёстой хэмээн эрх зүйн хувьд заагаагүй байдаг. Харин 1961-1990 оны хооронд харьяат бологсдын хэзээ орж ирсэн мэдээлэл болон БНМАУ-ын харьяат болсон оныг нэгтгэн харвал БНМАУ-д 2-10 жил болсон 15 хүн, 11-20 жил болсон 60 хүн, 21-30 жил болсон 113 хүн, 31-37 жил болсон 11 хүн, 41-48 жил болсон 12 хүн, 52-59 жил болсон 5 хүн байна. 10 жилээс доош БНМАУ-д амьдарсан мөртлөө харьяат болсон хүмүүс нь бүгдээр 15-аас доош насны хүүхдүүд байна. Үүнээс харахад эцэг эхийг нь сайн шалгасан бол хүүхдүүдийг харьяат болгон авахдаа “тэдэн жил амьдарсан” байх шалгуур тавьдаггүй байсан бололтой. Дээрх баримтаас үзвэл БНМАУ-ын харьяат болохын тулд насанд хүрсэн хүн БНМАУ-ын нутаг дэвсгэрт дор хаяж 10 жил амьдарч, оршин сууж байж харьяат иргэн болох шалгуураа давдаг байсан бололтой. 50-аас дээш жил Монголд суун харьяат болсон иргэдийн ихэнх нь хятадууд байгаа бөгөөд БНМАУ хятадуудыг харьяат болгон авахдаа маш олон жил Монголын нутагт суусан, өндөр настай хятадуудыг харьяатаар авч байсан бололтой харагдаж байна.

Мөн 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат болсон иргэдийн хэзээ орж ирсэн мэдээлэл болон насны байдлыг нэгтгэн харьцуулан харвал БНМАУ-д өлгийтэй байхаас 15 хүртэлх настай байхдаа орж ирсэн 41 хүн, 16-29 насандаа орж ирсэн 97 хүн, 30-39 насандаа орж ирсэн 40 хүн, 40-67 насандаа орж ирсэн 13 хүн байна. Эндээс харахад 16-29 насны залуучууд түлхүүтэй БНМАУ-руу дүрвэн,

³⁸ Мөн тэнд, 222

³⁹ Гансүх, П. *Монгол улсын хүн ам зүйн менежмент*, Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК, 2000, 86

⁴⁰ Харьатын тухай хууль, 1995 он, <https://www.legalinfo.mn/law/details/525>

хил зөрчиж орж ирж байсан нь харагдаж байна. Харьят болсон иргэдийн зарим нь өргөдөл дээрээр яах гэж орж ирсэн шалтгаанаа бичсэн байх бөгөөд үүнд, 1933 онд орж ирсэн буриад иргэн Н малын зам хянагчийн ажлаар Алтанбулагийн боомтоор орж ирээд тэр чигтээ БНМАУ-ын нутагт үлдсэн байна. 1940 онд гадаадын иргэн Р Алаг морьтын хилээр мал хариулж орж ирээд төөрөлдөн дайны үе байсан тул 5 жилийн ял сонсож, тэр чигтээ БНМАУ-ын нутагт үлдсэн байна. 1945 онд суралцахаар ирсэн өвөр монгол иргэн ч байна. Мөн өвөр монгол иргэн А 1944 онд Гоминданы цэрэгт хүчээр элсүүлсэн учир 7-р сард оргож хил зөрчиж ирээд Монголд 12 жил байж байгаад, Монгол, Хятадын харилцаа дулаарч эхлэхэд буюу 1956 онд нутаг буцаж, Хятадад амьдарч байгаад өвөр монголчуудыг ээлж дараалан шахсан бодлого гарч эхэлсний дараа 1962 онд дахин БНМАУ-ын хил зөрчиж ирсэн байна. Эдгээрээс үзвэл шилжилт хөдөлгөөнд тухайн үеийн улс төр, нийгмийн нөхцөл байдал шууд нөлөөлдгийг харж болно.

БНМАУ-ын харьяат бологсдын хил нэвтэрч ирсэн чиглэл

Хаагуур орж ирсэн нь мэдэгдэж буй нийт 18 хүний мэдээлэл байна. Үүнд Булган аймгаар 2, Дорноговь аймгаар 3, Сэлэнгэ аймгаар 1, Дорнод аймгаар 5, Сүхбаатар аймгаар 4, Баян-Өлгий аймгаар 2, Өмнөговь аймгаар 1 хүн орж ирсэн байна. Албан ажлаар явж байсан хүмүүс Алтанбулаг болон Замын-Үүдийн боомтоор орж ирсэн байгаа бол бусад хүмүүс өөр газраар хил зөрчиж орж ирсэн байна. Мэдэгдэж буй баримтаас харахад өвөр монголчууд Дорнод болон Сүхбаатар аймгаар илүүтэй орж ирдэг байсан байна. 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат бологсдын өргөдөлд тэд Булган аймгийн Хэнтий сумын Ордого⁴¹ хэмээх газраар, Баян-Өлгий аймгийн Дэлүүн болон Булган сумын нутгаар, Дорнод аймгийн Алаг морьтын хил⁴², Халх цагаан овоо⁴³, Дорнодын хязгаар, Халх голын Баян хошууны пунктээр⁴⁴, Дорноговь аймгийн Сулинхээрээр⁴⁵, Сүхбаатар аймгийн Чоно голоор⁴⁶ орж ирсэн байна.

Дүгнэлт

1. 1926 онд Монгол Улс анх удаа гадаадын харьяатуудыг зохицуулах дүрэмтэй болжээ. Тус дүрмээр харьяат болгон авах эцсийн шийдвэрийг Гадаад явдлын яам гаргах эрхтэй болжээ. 1941 оноос шинэчилсэн дүрмийг гаргасан бөгөөд уг дүрмээр харьяат болгох эцсийн шийдвэрийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид гаргадаг болсон байна. Тус дүрмийг 1959 он хүртэл хэрэглэсэн бөгөөд 1959 оноос харьяатын тухай асуудлыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчид шийддэг болсон байна. 1974 оноос харьяатын тухай цогц хуультай болсон бөгөөд үүнд өсөн тэлж байсан гадаад бодлого

⁴¹ Одоогийн Булган аймгийн Тэшиг сумын нутаг

⁴² Одоогийн Дорнод аймгийн Халхгол сумын нутаг

⁴³ Одоогийн Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутаг

⁴⁴ Одоогийн Дорнод аймгийн Халхгол сумын нутаг

⁴⁵ Одоогийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг

⁴⁶ Одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг

нөлөөлсөн бололтой. Гэвч энэхүү хууль гарсны дараа харьяат бологчдын тоо 1980-аад оны сүүл хүртэл буурсан байна. Энэхүү хуулийг хууль дүрмийг засах 5 жилийн төлөвлөгөөгөөр 1987 онд шинэчлэн найруулсан байна. Бидний авч үзсэн 1961-1990 оны хугацаанд 1961-1974 оны үеийг 1959 оны БНМАУ-ын харьяат болгон авах тухай заавраар, 1974-1987 оны үеийг 1974 оны харьяатын тухай хуулиар, 1987-1990 оны үеийг 1987 оны шинэчилсэн хуулиар зохицуулдаг байсан байна. Мөн харьяат болгон авах эцсийн шийдвэрийг үргэлж засаг захиргааны томоохон байгууллага шийдэн гаргадаг байжээ. 1941 оноос эхлэн БНМАУ-ын харьяат болохыг хүссэн гадаадын иргэдийг ихээхэн хянаж, шалган, хувийн мэдээллийг харгалзан үзэж харьяат болгон авдаг байсан нь тодорхой харагдаж байна.

2. 1961-1990 оны хооронд нийтдээ 1,031 хүн БНМАУ-ын харьяат болсон бөгөөд энэ хооронд 1960-аад онд гадаадын иргэдийг хамгийн олноор харьяат болгон авсан байна. ЗХУ болон БНХАУ-ын харилцаа хүйтрэх үеэс харьяат бологсдын тоо даган буурч байна. 1980 онд харьяат бологсдын тоо хамгийн доод цэгтээ хүрч байгаа нь мөн л Монгол, Хятадын харилцаатай холбоотой байна. 1988 оноос ЗХУ, БНХАУ-ын харилцаа сайжрахтай зэрэгцэн харьяат бологсдын тоо 1990 он хүртэл өссөн байна. Эндээс харвал БНМАУ-ын харьяат бологсдын тоо Монгол, Хятадын харилцаанаас шууд хамааралтай байна.

3. 1961-1990 оны хооронд нийт 1,031 хүн БНМАУ-ын харьяат иргэн болсноос 318 нь БНХАУ-ын харьяалалтай, 7 нь ЗХУ-ын харьяалалтай, 587 нь аль ч улсын харьяалалгүй, 119 хүний харьяалал нь тодорхойгүй байна. Харин аль ч улсын харьяалалгүй 587 иргэний 143 нь БНХАУ-ын харьяат байж байгаад гарсан, 31 нь ЗХУ-ын харьяат байж байгаад гарсан, 413 хүний өмнөх харьяаллын мэдээлэл тодорхойгүй байна. Эдгээр иргэдийг яс үндсээр нь ялгавал Өвөрмонгол 587, хятад 249, орос 26, халх 11, буриад 28, казах 10, солонгос 1, узбек 3, уйгур 3, үндэс угсаа нь тодорхойгүй 113 хүн байна. Улсын харьяалал болон үндэс угсааны байдлаас харвал 1961-1990 онд БНМАУ-ын харьяат иргэн болсон иргэдийн 80 гаруй хувь нь БНХАУ-ын иргэн, талаас илүү хувь нь Монгол үндэстний хүмүүс байсан нь тодорхой харагдаж байна. Мөн үндэс угсаа нь тодорхойгүй хүмүүсийн нэрийг харвал монгол, буриад нэр зонхилж байх бөгөөд эдгээр нь монгол угсаатны хүн байсан гэж үзвэл 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат иргэн болсон хүмүүсийн 70 гаруй хувийг Монгол үндэс, угсааны хүмүүс эзэлж байжээ. Үүнээс харвал БНМАУ гадаадын иргэдийг харьяат иргэн болгон авахдаа Монгол угсаатныг түлхүү хүлээн авдаг байсан нь тодорхой харагдаж байна.

4. Хүйсийн мэдээлэл нь мэдэгдэж буй 471 хүний 334 нь эрэгтэй, 137 эмэгтэй байна. Үүнээс харвал БНМАУ харьяат иргэн болгохдоо эрэгтэй хүйсийг түлхүү харгалзан үздэг байсан байна. Насны хувьд 0-20, 41-60 насны хүмүүсийг түлхүүтэй харьяат иргэн болгосон байна.

5. Нийт харьяат болсон хүмүүсийн 90 гаруй хувь нь Улаанбаатар хот, төв, зүүн бүсийн нутагт байрлаж байжээ.

6. Мэдэгдэж буй баримтаар 1961-1990 оны хооронд харьяат болсон иргэдийн орж ирсэн он цагийг гурван үе болгон хуваан үзэв. 1961-1990 оны хооронд

БНМАУ-ын харьяат болсон иргэдийн дийлэнх нь 1945 он, 1956-1961, 1962-1969 оны хооронд орж иржээ. Энэхүү шилжилт хөдөлгөөнд БНХАУ-ын дотооддоо явуулсан бодлого ихээхэн нөлөөлжээ. Мөн эдгээр иргэд БНМАУ-д Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Сэлэнгэ аймгуудаар орж ирсэн байна. Мөн эдгээр иргэдийн талаас илүү хувь нь хувийн хэргээр орж ирсэн хэмээн мэдүүлжээ.

7. Харьяат бологсдын орж ирсэн хугацаа болон насны байдлыг харгалзан авч үзвэл 10-аас доош жил БНМАУ-д амьдарч байгаад харьяат болсон иргэд нь бүгдээрээ 15-аас доош насны хүүхдүүд байна. Харин насанд хүрсэн гадаадын иргэд БНМАУ-д дор хаяж 10 орчим жил амьдарч байж БНМАУ-ын харьяат болсон байна. Үүнээс харвал харьяат болгох хууль, дүрэмд заагаагүй нэгэн “шалгуур” нь БНМАУ-д дор хаяж 10 жил оршин суусан байх байжээ.

8. Дээрх мэдээллүүдийг дүгнэн БНМАУ 1961-1990 оны хооронд гадаадын иргэдийг харьяат болгон авахдаа дараах бодлогыг баримталж байсан хэмээн таамаглаж байна. Үүнд:

- Монгол угсаатан байвал илүүтэй дэмжих
- Насанд хүрсэн гадаадын иргэн Монголд орж ирээд болон төрөөд дор хаяж 10 жил БНМАУ-ын нутагт амьдарч, оршин суусан байх
- Эцэг эхийг сайн шалгасан бол хүүхдийг заавал 10 жил амьдарсан эсэхийг тооцолгүй харьяатаар авах
- БНМАУ-д төрүүлсэн хүүхэдтэй байх.

1960-аад оноос эхлэн монголчууд социалист интернационалч үзлийг үндэсний үзлээс дээгүүр тавьж, үндэсний үзлийг илээр хорьж эхэлсэн юм. Харин дээрх баримтуудыг харвал 1961-1990 оны хооронд БНМАУ социалист интернационалч бодлогын далбаан доор угсаа гарал нэгтнээ илүүтэй харьяат иргэн болгон авч байсан нь харагдаж байна. Харьяат болохыг хүссэн гадаадын иргэдийг үндэс угсаагаар нь ялган, ангилах нь үндэсний үзэл санааны шууд илэрхийлэл мөн бөгөөд социалист интернационалч үзлийн цаана ч БНМАУ-ын нам төр үндэстнээ нэгтгэх бодлогыг бага боловч тасралтгүй хэрэгжүүлж байсан нь тодорхой байна.

Abstract

From the moment Mongolia declared its independence in 1911, the country remained committed to the policy of uniting the Mongol ethnic groups until the mid-20th century, culminating in the 1945 Liberation War. However, due to the geopolitical landscape and the interests of major powers at the time, this policy faced significant challenges and was not always successful. After the founding of the People's Republic of China in 1949, and especially from the 1960s onward, the Mongolian People's Republic (MPR) fully adopted a socialist internationalist approach in both its domestic and foreign policies. As a result, nationalist ideals were openly condemned and restricted, and the policy of ethnic unification gradually disappeared from public discourse. Nevertheless, in practice, the MPR continued to prioritize granting citizenship to ethnic Mongols and discreetly pursued an ethno-demographic resettlement policy, even under the overarching framework of socialist internationalism.

Хавсралт

Хүснэгт 1. 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат иргэн бологсдын нийт тоо

О н	Бүх дагаар орогчид	Өвөр монгол	Хятад	Орос	Буриад	Казах	Бусад	Халх	Үндэс угсаа тодорхойгүй
1961	190	96	77	1	5	10			1
1962	262	119	122	10	1				10
1963	61	35	16	7			1		2
1964	43	31	7	1	4				
1965	31	24	4		1				2
1966	29	25	2				1		1
1967	36	26	2		1		1		6
1968	22	15	4	2					1
1969	16	12	1	1	2				
1970	13	10	1		2				
1971	27	21	2		4				
1972	7	7							
1973	22	20						1	1
1974	62	53	6				2	1	
1975	30	26	1		2			1	
1976	11	8	3						
1977	26	18		2	3			3	
1978	12	8		1				3	
1979	4	3			1				
1980	3	3							
1982	3			1	1			1	
1984	3								3
1985	5								5
1986	1				1				
1988	4								4
1989	26								26
1990	82	27	1				2	1	51
Дүн	1031	587	249	26	28	10	7	11	113

*Хүснэгт 2. 1961-1990 хооронд БНМАУ харьяат бологсдын байршил болоод
үндэс угсааны байдал*

	Нийт харьяат бологчид	Өвөр монгол	Хятад	Орос	Буриад	Казах	Бусад	Халх	Үндэс угсаа тодорхойгүй
Архангай	1		1						
Баян-Өлгий	1						1		
Баянхонгор	6	2	3						1
Булган	88	35	48		3			1	1
Дархан хот	11	10	1						
Дорноговь аймаг	38	33	3	1					1
Дорнод	45	36	7						2
Завхан	7	2	5						
Өвөрхангай	2	1							1
Өмнөговь	21	20	1						
Сүхбаатар	10	9							1
Сэлэнгэ	39	31	4		1				3
Төв	56	46	8						2
Улаанбаатар	573	342	163	23	22		4	10	9
Увс	4	3					1		
Ховд	12	1				10	1		
Хөвсгөл	2	1		1					
Хэнтий	19	13	5						1
Эрдэнэт хот	2	2							

*Хүснэгт 3. 1961-1990 оны хооронд Улаанбаатар хотод байрлаж байсан
БНМАУ-ын харьяат бологсдын тоо*

	Чойбалсангийн хороо	Хоршооллын хороо	Төмөр замын хороо	Чингэлтэйн хороо	Амгаланбаатарын хороо	Зүүн сэлбийн хороо	Ажилчны хороо	Сүхбаатарын хороо	Толгойтын хороо	Амгалангийн хороо	Найрамдлын хороо	Уурхайчдын хороо	Налайх хот	Октябрийн хороо	Найрамдлын район	Сүхбаатарын район	Октябрийн район	Ажилчны район	Нийт
1961	3	2	1	11	1	1													19
1962	32	18	13	39		30	16	9	23	14	18	6							218
1963		5	8	18		1	4				3		4	2					45
1964		1		3		1	1	2	1		3		5	7					24
1965				1		1					3					1			6
1966								1											1
1967															3	3	19		25
1968													1			5	3	6	15
1969															1	5	5	1	12
1970													2		1	4	1	1	9
1971															3	13	1	10	27
1972																2	2	1	5
1973															1	8	1	6	16
1974															5	32	15	8	60
1975															7	16	2	2	27
1976															1	1	6	1	9
1977															15	7		3	25
1978															3	4	1	4	12
1979															2				2
1980																3			3
1981																			
1982																2	1		3
1983																			
1984																			
1985																2			2
1986																			
1987																			
1988																			
1989																			
1990																			

Хүснэгт 4. 1961-1990 оны хооронд БНМАУ-ын харьяат болсон Улаанбаатарт байрлаж байсан иргэдийн үндэс угсааны талаарх мэдээлэл

	Өвөр монгол	Хятад	Орос	Буриад	Бусад	Халх	Тодорхойгүй
Чойбалсангийн хороо	14	19	1	1			
Хоршооллын хороо	9	17					
Төмөр замын хороо	15	3	4				
Чингэлтэйн хороо	25	36	10	1			
Амгаланбаатарын хороо				1			
Зүүн сэлбийн хороо	6	27	1				
Ажилчны хороо	11	10					
Сүхбаатарын хороо	4	8					
Толгойтын хороо	23	1					
Амгалангийн хороо	4	10					
Найрамдлын хороо	12	15					
Уурхайчдын хороо	3	3					
Октябрын хороо	7		1		1		
Найрамдлын район	31		2	3	1	3	2
Сүхбаатарын район	78	6	1	8	1	7	7
Октябрын район	49	5	2	1			
Ажилчны район	39	1	1	2			
Налайх	5	2		5			

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

- Алтантөгс, Н. 1954 оны Монгол-Хятадын ажиллах хүчний хэлэлцээрийн хүрээнд Өвөр Монголоос ажилчин авах Монголын бодлого. *Journal of International Studies*. 46, 115 (Nov. 2023), 96–110. DOI: <https://doi.org/10.5564/jis.v46i115.3081>
- Батсайхан, О. нар. *Монголын түүх 1911-2017*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2018
- Болдбаатар, Ж. *Миний хоцрогдсоныг дэлхий мэднэ...*, Булган хот: Дэвшил компани 1994
- Болдбаатар, Ж. нар. *Монгол улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: Хувьсал өөрчлөлт (XX зуун)*, Улаанбаатар:Соёмбо Принтинг ХХК 2008
- Болдбаатар, Ж. Дашдаваа, Ч. *Шинэчлэлийн төлөө хөдөлгөөн,түүний хувь заяа*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2005
- Булаг, Э. *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*, Улаанбаатар: МУИС Пресс хэвлэлийн газар 2016
- *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл (1921-1940)*,Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар 1972
- *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл (1941-1970)*,Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар 1974
- *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндсэн хууль, Улс төр эрх зүйн дэлгэрэнгүй тайлбар*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар 1988
- *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эрүүгийн эрх*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо 1965
- Гансүх, П. *Монгол улсын хүн ам зүйн менежмент*, Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК 2000
- Гэрэлчулуун, Х. *Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн, Оюутны гарын авлага*, Улаанбаатар: ВСИ Хэвлэлийн газар 2013
- Жамбалсүрэн, Ц. Ю. *Цэдэнбал эрин зууны түүхэн элч*, Улаанбаатар: МУИС Эрдэм судлалын төв 2007
- Лигдэн, Б. *БНМАУ-ын гадаад харилцааг хөгжүүлэх талаар МАХН-аас явуулсан үйл ажиллагаа (1945-1970)*, Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар 1976
- *Монгол Зөвлөлтийн харилцааны түүх (1921-1978)*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар 1981
- *Монгол улсын хүн ам хорьдугаар зуунд*, Улаанбаатар: Үндэсний Статистикийн газар 2003
- Мэндсайхан, Х. “Монгол улсын төрөөс гадаадын иргэн, харьяатын талаар хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ (1921-1930)”, *Acta Historica IX*, 2008
- Мэндсайхан, Х. *Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяатын асуудал: 1921-1940*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2012
- Мягмарсамбуу, Г. *Баргын эрх чөлөөний тэмцэл: Нүүдэл, суудал*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК 2007
- Наранжаргал, Д. *Хятад ажилчид БНМАУ-д (1949-1964)*, Улаанбаатар: Сэлэнгэ Пресс 2019
- Нарантулга, Б. *Монголын нийгэм дэх шилжих хөдөлгөөн*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК ХХК 2018
- Норовсамбуу, С. Дашжамц, Д. *Өнгөрсний үлдэгдэл, өнөөгийн сөрөг үзэгдэл, түүнийг даван туулах асуудал*, Улаанбаатар: ШУАХ 1988

- Нэргүй, Ц. Золзаяа, Н. Мэндсайхан, Х. Монголын харьяат, цагаачлалын түүх (нэн эртнээс-1922 он хүртэл), Мөнхийн үсэг ХХК: Улаанбаатар 2006
- Огонус Цогту, Монгол хүн ба соёлын хувьсгал, Улаанбаатар: Монсудар 2017
- Оюунтунгалаг, А. Монгол улсын буриадууд, Улаанбаатар: МУБИС 2004
- Тамир, Э. Хятадын түүх (XVII-XX), Улаанбаатар: 2001
- Урангуа, Ж. Дайны золиос болсон хүмүүс: 1945-1947 онд Монголд байсан Япончууд, Улаанбаатар: 2018
- Хишигт, Н. “Тусгаар тогтнолын асуудал”, Эрдэмтдийн үг цуврал лекц 10, 2016
- Хөхбаатар, Б. “БНМАУ-ын 1945 оны чөлөөлөх дайны зорилт ба өвөр монгол”, ХХ зууны монголын түүх, соёлын зарим асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019
- Пүрэв, О. Монгол улсын түүхэн газарзүй, Улаанбаатар: Адмон пресс 2004
- Цэдэв, Ц. Монгол улсын хүн ам, нөхөн үржихүйн асуудлууд (Онол, шинжилгээ, төсөөлөл), Улаанбаатар: ХААН Принтинг ХХК 1999
- Цэрэнсодном, Х. Монголын хүн амын байршилт динамик ба газарзүйн орчин, Улаанбаатар: 1999
- Цэрэнсодном, Х. Монголын хүн ам ба хүрээлэн буй орчин, Улаанбаатар: 2003

Англи хэлээр

- Diehl, Kenneth R. “Cities, population redistribution, and urbanization in Mongolia, 1918-1990.” Ph.D. diss., Indiana University. 1994.

Архивын баримт

- | | |
|-----------------------------|-----------------------------|
| - МУҮТА Х.11, Д.3, ХН.409 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 732 |
| - МУҮТА Х.11, Д.1, ХН. 310 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 733 |
| - МУҮТА Х.11, Д.1, ХН. 523 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 808 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1394 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 809 |
| - МУҮТА Х.11, Д.3, ХН. 551 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 870 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 508 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 871 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 509 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 872 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 511 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 934 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 512 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 935 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 541 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 937 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 542 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 938 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 543 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1029 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 590 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1030 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 591 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1092 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 592 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1093 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 635 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1094 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 636 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1095 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 637 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1148 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 681 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1149 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 682 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1254 |
| - МУҮТА Х.11, Д.2, ХН. 683 | - МУҮТА Х.11, Д.2, ХН. 1255 |

- | | |
|-----------------------------|-----------------------------|
| - МУУТА Х.11, Д.2, ХН. 1256 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 398 |
| - МУУТА Х.11, Д.2, ХН. 1386 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 400 |
| - МУУТА Х.11, Д.2, ХН. 1388 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 548 |
| - МУУТА Х.11, Д.2, ХН. 1389 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 853 |
| - МУУТА Х.11, Д.2, ХН. 1511 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 1163 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 13 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 1320 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 15 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 1549 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 157 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 1855 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 160 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 2013 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 161 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 2014 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 162 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 2189 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 163 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 2190 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 274 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 2191 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 276 | - МУУТА Х.11, Д.3, ХН. 219 |
| - МУУТА Х.11, Д.3, ХН. 396 | |